

## **Позитив, норматив дүрсийн онол ба пүүсийн орлогын тайлан**

Т. Жааваа<sup>1</sup>

### **Хураангуй**

Нягтлан бодох бүртгэлийн мэргэжилд том байр эзэлдэг позитив, норматив дүрсийн онол хийгээд дэлхийн улсуудын санхүүгийн бүртгэлд түгээмэл дэлгэрсэн нягтлан бодох бүртгэлийн (эсвэл, санхүүгийн ашиг) ашгийн дүрст өгөгдлийн сан (НББАДӨС), тэрчлэн макро эдийн засгийн үндэсний тооцооны системийг дэмждэг татварын зорилготой ашгийн хэмжлийн загвар (ТЗАХЗ) хийгээд микро экономикс ухаан, түүний пүүсийн онол болон орчин үеийн удирдлагын бүртгэлд дэлгэрч буй эдийн засгийн ашгийн хэмжлийн загвар (ЭЗАХЗ) ба эдийн засгийн ашгийн дүрст өгөгдлийн сангийн (ТЗАДӨС) онол, үндсэн тавил, байгууламжийг зохиогчийн олон улсад тавьсан илтгэл, ном, сэтгүүлд хэвлүүлсэн эх сурвалжид түшиж, нэгтгэн эвлүүлж бичлээ.

*Түлхүүр үгс:* бизнес хавтгай, эдийн засгийн үнэ цэнэ, позитив норматив дүрс, пүүсийн тайлан, ашгийн инженерчлэл, хэмжлийн парадигм, өгөгдлийн сан, нэмүү өртгийн хэмжил

---

<sup>1</sup> МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхимийн доктор (Sc.D), профессор  
E-mail: tjaavaa@yahoo.com

## Үндсэн агуулга

**Эдийн засгийн үнэ цэнэ** (*Economic Value*) - далд утгатай нууцгай хувьсагч (Jaavaa, 2007, 2008). Энэ бол боломж, хүлээлт. Тэрбээр, геометр дүрс юм. Бас мөнхийн хөдөлгөөнд оршдог, их урсамтгай гадаргуй. Биет ба биет бус юмсыг тойрсон үнэ цэнэ, хүлээлт бүхэн тодорхойгүй бөгөөд ил болон далд (мэдэрсэн, мэдрээгүй) хэмжээстэй. Орчин цагийн хэмжлийн парадигм, үйлдлийн шинжилгээ, реинженеринг, загварчлалгүй өгөгдлийн сан үүсгэн дүрсжүүлж, эргэлтэд өгөх боломжгүй юм.

Бүх боломж, хүлээлтүүдтэй нь жишихэд, санхүүгийн хэмжлээр мэдэрч, эргэлтэд өгсөн нь тун ч аривчгүй. Заан туулайн үлгэртэй зүйрлэхэд туулайн чинээ ч биш, харин хязгааргүй тэнгис дотор хөвж яваа олон жижиг усан онгоц шиг өчүүхэн цэгнүүд мэт харагдана. *Тэгэхлээр, алив мэдээ, параметр буюу индикатор багц (Indicator Sets) гэж хязгааргүй далай дунд хөвөгч дусал талст төдий зүйл юм* (Jaavaa, 2009; Жааваа, 2012). Улс гүрний үндэсний тооцооны систем, дэлхийн эдийн засгийг байгаа бүх боломж, хүлээлтүүдтэй нь жишихэд ийм өчүүхэн цэг шиг юм. Тэгвэл, даац ихтэй далд, бичил гадаргуйд яаж нэвтрэх вэ? Сүүлийн үес бүхий л онол, нээлт, загварууд ил гадаргуйд тоглолт хийхийн чацуу энэ тухай илүүтэй бясалгаж судлах болсон.

Эдийн засгийн үнэ цэнэ урсамтгай шинжтэй юм. Торгон агшинд мэдрээгүй асар их боломж, хүлээлтүүд төвөөс зугтах хүч, хуулийн үйлчлэлийн дагуу хормын зуур эргэлтээс замхарч, үүрд гадагшлан эсрэг бие - өрсөлдөгч рүү шилжиж, халаасыг нь зузаатгадаг. Ерөөс бид төгс бус бүтэц, үйлчилгээний соёл, мэдээллийн тогтолцооноос асар их үнэ цэнэ, боломж

хүлээлтүүдийг мэдрэхгүй алдаж, тэр нь өрсөлдөөн, хүчний тэнцвэрт нөлөөлж буйг анзаардаг гэж үү? Туйлын төгс дизайн, инженерчлэл, пүүсийн бүтэц, байгууламж, үйлчилгээний соёл, мэдээллийн тогтолцоо гэж үгүй. Нөгөө талаас, алив инженерчлэл, шийдлүүд болон сэдлийн цаана асар их, нууцлаг гадаргуйг (далд биет) ил гаргахыг үгүйсгэхгүй.

Алив өгөгдлийн сан, мэдээ параметр, индикатор багц үүсгэх сонголтот горимын цаана бүртгэлийн позитив, норматив дүрсийн онол, эдийн засгийн үнэ цэнийн хэмжлийн суурь загвар, пүүсийн орлогын IS-AC-GM & IS-DC-CM зохиомж, орчин үеийн санхүүгийн ба менежмент бүртгэлийн тавилууд оршдог юм. Ялангуяа нягтлан бодох бүртгэлийн позитив, норматив дүрсийн үзэл парадоксын дагуу бизнес хавтгайг инженерчилж зураглах мэргэжлийн чиг хандлага болон хэмжлийн парадигмийн ой санамж төгсжүүлэх чигт сэтгэлгээний урсгал их тэлж байна.

Бүртгэлийн позитив болон норматив дүрс гэж юу вэ? **Позитив дүрс** - мэдэрсэн талбайн түүхчлэл. *Позитив эх сурвалж* гэж ил гадаргуй (талбай) дэх мэдэрч дүрсжүүлсэн үнэ цэнэ. Үйл явцыг өргөн багтаамжтай дүрсэлж түүхчилдэг. Дүрсжсэн үйл явц, үнэ цэнэ, хормын дараа түүх болж үлддэг. Позитив дүрс - улс гүрний макро эдийн засгийг инженерчилж, үндэсний тооцооны систем үүсгэх, макро эдийн засгийн жолоодлогын параметр тэлэх, үндэсний гааль, татвар, даатгалын тогтолцоог дэмжихэд зориулагдсан (Жааваа, 2015).

Позитив дүрсийн суурь бүтээлүүд:

- Grady, P. (1965). *Inventory of Generally Accepted Accounting Principles for Business Enterprises*. Accounting Research Study - 7. AICPA;

- Ijiri, Y. (1967). *The Foundations of Accounting Measurement*. New Jersey: Prentice Hall;
  - Christensen, C. (1983). The Methodology of Positive Accounting. *The Accounting Review*, 58(1), 1-22;
  - Watts, R. L., & Zimmerman, J. L. (1986). *Positive Accounting Theory*. New Jersey: Prentice Hall;
  - Watts, R. L., & Zimmerman, J. L. (1990). Positive Accounting Theory: A Ten Year Perspective. *The Accounting Review*, 65(1), 131-156;
  - Whittington, G. (1987). Positive Accounting: A Review Article. *Journal of Accounting and Business Research*, 17(68), 327-336;
  - Demski, J. S. (1988). Positive Accounting Theory: A Review. *Accounting, Organizations and Society*, 13(6), 623-629;
  - Mouck, T. (1990). Positive Accounting Theory as a Lakatosian Research Programme. *Accounting and Business Research*, 20(79), 231-239;
  - Boland, L. A., & Gordon, I. M. (1992). Criticizing Positive Accounting Theory. *Contemporary Accounting Research*, 9(1), 147-170;
  - Chambers, R. J. (1993). Positive Accounting Theory and the PA Cult, *Abacus*, 29(1), 1-26.
- Норматив дүрс** гэж угтаж харсан (ирээдүй) үнэ цэнэ, талбайн зураг, *норматив эх сурвалж* - ирээдүйд чиглэсэн гадаргуй, далд (мэдрээгүй) талбайд нэвтэрч, эргэлтэд өгөхийг хэлнэ. Өмнөх үйл явцаас ирээдүйг угтаж харсан параметр, (жолоодлогын) багцууд үүсгэх ба далд талбайд нэвтэрдэг (Жааваа, 2015). Хүснэгт 1-т эдийн засгийн үнэ цэнийн хэмжлийн суурь хоёр загварыг нягтлан бодох бүртгэлийн позитив болон норматив дүрсийн дагуу жишиж харуулсан.
- Норматив дүрсийн шав тавигсад:
- Boland, L. A., & Gordon, I. M. (1992). Criticizing Positive Accounting Theory. *Contemporary Accounting Research*, 9(1), 147-170;
  - Chambers, R. J. (1993). Positive Accounting Theory and the PA Cult, *Abacus*, 29(1), 1-26.

Хүснэгт 1. Эдийн засгийн үнэ цэнийн хэмжлийн загвар

APMM & APIS	EPMM & EPIS
- Статик тавилтай	- Динамик тавилтай
- Нэг хэмжээст позитив дүрс	- Олон хэмжээс дүрс
- Ил урсгал гадаргуй (тархац, түүх, зураг)	- Гүн инженерчилсэн далд гадаргуй
- Мөнгө, аккруаль сууриудын чөлөөт хөрвөлттэй макро эдийн засгийн өгөгдлийн сан	- Инженерчилсэн (микро экономикс) өгөгдлийн сан буюу жолоодлогын параметрууд
- Амьдралын мөчлөгийн үе шатны хэмжил	- Амьдралын мөчлөгийн бүрэн хэмжил

Тайлбар:

APMM - НББ-ийн мэргэжилд өргөн тархсан татварын зорилготой ашгийн хэмжлийн загвар (ТЗАХЗ), эсвэл санхүүгийн бүртгэл дэлгэрсэн НББ-ийн ашгийн хэмжлийн загвар (НББАХЗ) гэсэн англи хэллэгийн товчлол (Жааваа, 2015; Жааваа, 2008).

APIS - Макро эдийн засгийн үндэсний тооцооны системийг дэмждэг татварын зорилготой ашгийн дүрст өгөгдлийн сан (ТЗАДӨС), эсвэл дэлхийн улс гүрнүүдийн санхүүгийн бүртгэлд түгээмэл дэлгэрсэн НББ-ийн ашгийн дүрст өгөгдлийн сан (НББАДӨС).

EPMM - Микро экономикс ухаан, түүний пүүсийн онол болон орчин үеийн удирдлагын бүртгэлд дэлгэрч буй эдийн засгийн ашгийн хэмжлийн загвар (ЭЗАХЗ).

EPIS - Эдийн засгийн ашгийн дүрст өгөгдлийн сан (ТЗАДӨС).

Санхүү бүртгэл: APIS гадаргуй ба макро эдийн засгийн дүрслэл

Пүүсийн IS-AC-GM зохиомж, APIS гадаргуй ба хэмжлийн APMM парадигм - түүхэн өртөг, тогтмол (нэрлэсэн) үнэ, бодит үнэ (Fair Value) цэнийн хэмжил болон татварын ашгийн тэнхлэгт энгийн хувиргалт бүхий өгөгдлийн сангийн жолоодлогогүй загварыг үүсгэдэг (Jaavaa, 2009). Хэмжлүүд цаг үеийн мэдрэмтгий (PV, FV, NPV, CAPM гэх мэт) индикаторт суурилдаг ч хормын зуур хувьсаж өөр утга авдаг учир бүхэлдээ нэрлэсэн буюу тогтмол үнийн хэмжээс бүхий өгөгдлийн сангийн царцанги сүлжээг үүсгэдэг юм (Jaavaa, 2007). Энэ бүхэн позитив сурвалж: APMM & APIS гадаргуй, хэмжлийн парадигмын гол тавил, шинжүүд. Хэмжлүүд туйлын хялбар, ой санамж муу ч гэлээ, барьж өгсөн үнэ цэнэ, боломж, хүлээлтүүд нь том (макро) биетийг жолоодоход хангалттай бөгөөд хүрэлцээтэй нөхцөл болдог (Jaavaa, 2007, 2008).

Бүх сонгодог макро нээлт: төрийн зохицуулалт (Дж. Кэйнс), мөнгө, сангийн бодлого (Т.Фридман, П.Самуэльсон, Ж.Хикс, Р.Манделл), шугаман, транслог, орлуулалтын мэдрэмжтэй үйлдвэрлэлийн функц (Р.Харрод, Кобба-Дуглас, Ж.Хикс), эдийн засгийн мөчлөг, өсөлт (Р.Харрод, Э.Домар, П.Самуэльсон гэх мэт), Р.Солоу, Т.Сванс (1956), Е.Мийд (1961), Ж.Тобин (1965), Р.Лукасын (1988) шинэ сонгодог өсөлт, онол, нээлтүүд APIS-д суурилсан нь санамсаргүй зүйл биш.

Удирдлагын бүртгэл: EPIS гадаргуй ба микро эдийн засгийн зураг

Пүүсийн IS-DC-CM загвар, EPIS гадаргуй, хэмжлийн EPMM парадигм - бизнес, төсвийн ертөнцийг зурагласан мэдээллийн сүлжээ, төгс хэмжилт өгөгдлийн сангийн

сайжруулсан модель гэж ойлгогддог. EPMM & EPIS & Mic.EIS - ой санамж сайн, далд (бичил) талбайд их гүнзгий нэвтрэх боломж олгодог. Мэргэжил татварын ашгийн дүрсээс гадна олон хувилбараас сонголт хийж шийдвэр гаргахдаа алив хөрөнгө, бүтээгдэхүүн, үйлчилгээний амьдралын мөчлөг (*Life Cycle*) гэхчлэн их мэдрэмтгий хэмжилтүүд бүхий эдийн засгийн ашгийн дүрст өгөгдлийн санг (*EPIS*) илүүд үздэг.

Их мэдрэмж, санах ой багтаамж бүхий *бичил индикатор багцын* дэмээр олон хэмжээст *нууцдал гадаргуйг* эргэлтэд өгч, гадагш мөнгөний хүлээлтийг хаахад чиглэсэн. Динамик тавил, бодит үнэ, ил урсгал зардал, үйлдэл, процессын урсгал, дизайны инженеринг зураглал (загварчлал), мөчлөгийн хэмжлүүд (*Life Cycle Measurement Model*) ч сайн дэмждэг. Эцэст, позитив болон норматив дүрс: IS-AC-AP & IS-DC-EP зохиомж, APMM & EPMM дүрс, APIS & EPIS хэмжлийн парадигмд холбогдох ухагдахуун ба элементүүдийг базаж дүгнэх гэж оролдоё.

*Бизнес хавтгайг нил бүрхсэн эдийн засгийн үнэ цэнийн гадаргуйг ил ба далд (мэдэрсэн, мэдрээгүй) гэсэн хоёр хэсэгт хувааж үзнэ.* Бүх хэмжээстэй нь жишихэд, санхүүгийн хэмжлээр ил гарч (мэдэрч), эргэлтэд очсон нь тун ч аривчгүй юм. Зүйрлэвээс, бүх гадаргуй - тэнгис, ил гадаргуй - тэр дотор хөвж яваа жижиг усан онгоц гэсэн үг. Позитив эх сурвалж: IS-AC-GM & APMM & APIS - ил талбайн гадаргуйг тогтмол үнийн дүнгээр мэдэрч, хатуу нэг хэмжээсээр түүхчилж дүрсжүүлдэг. Харин норматив сурвалж: IS-DC-CM & EPMM & EPIS - олон хэмжээст норматив дүрс, инженерчлэл бизнес хавтгайд буй хараахан мэдрэгдээгүй, далд (бичил) гадаргуйд нэвтэрч, эргэлтэд барьж өгдөг.

Санхүүгийн бүртгэл - позитив дүрсийг татварын ашгийн тэнхлэгээр түүхчлэх, удирдлагын бүртгэл - норматив дүрслэл: далд талбайг мэдэрч, эргэлтэд өгөхөд оршино. Нэг нь статик тавил, позитив дүрслэл, суурийн чөлөөт хөрвөлттэй, нөгөө нь динамик тавил, норматив дүрслэл, гүн инженерчилсэн гадаргуй бүхий мөчлөгийн хэмжлүүдтэй юм (Jaavaa, 2009). Ийм парадоксаар мэргэжлийн чиг үүргийг үнэлэх сэтгэлгээний хандлага тэлж буй.

#### Удирдлагын бүртгэлийн хөгжлийн хандлага

Удирдлагын бүртгэлийн мэдээллийн систем нь эдүгээ байгууллагын төлөвлөлт, төсөвлөлт, зохион байгуулалт, хяналт үнэлгээг дэмжихээс гадна удирдлагын шийдвэр гаргалтыг илүүтэй дэмжих болсон. Ялангуяа шийдвэр гаргалтыг оновчлох, байгууллагын стратегийг дэмжих мэдээллийг бэлтгэх шаардлагуудыг тавьдаг болжээ. Удирдлагын тодорхой түвшний шийдвэрийг дэмжих мэдээллийг хэрхэн бэлтгэж буйгаас дараах 3 бүлэгт (Garrison, 1997) багцалж үзнэ.

*Удирдлагын суурь шийдвэр гаргалтыг дэмжих мэдээллийг боловсруулах:* бүтээгдэхүүн үйлчилгээний өртгийг хэмжих, өртгийн динамик шинжилгээ хийх, төсөв боловсруулалт, хэлбэлзлийн шинжилгээ хийх, ашгийн төлөвлөлт хийх.

*Удирдлагын шийдвэрийг дэмжигч мэдээллийг бэлтгэх:* шийдвэр гаргалтад уяж өртгийг ангилах, зардал тоо хэмжээ ашгийн хамаарлыг тооцох, стандарт өртөг хэлбэлзлийн шинжилгээ хийх, хариуцлагын төвүүдийг үнэлэх буюу үр дүнгийн үнэлгээ хийх.

*Стратегийг дэмжих мэдээллийг боловсруулах:* алив хөрөнгө, бүтээгдэхүүн

үйлчилгээний амьдралын мөчлөгийн хэмжилт хийх, амьдралын мөчлөгийн өртөг тооцох, зорилтот өртөг тооцох, кайзен систем нэвтрүүлэх, тэнцвэржүүлсэн үнэлгээний хуудас ашиглах гэх мэт.

#### Бизнес хавтгай дэх ашгийн инженерчлэл

Пүүсийн **ашгийн дүрсийг** инженерчлэхэд, бүрэн шингээлтийн (*Absorption Costing*) болон шууд өртөг тооцолт (*Direct Costing*)-ын сууриас шалтгаалж, орлогын тайланд ялгаатай хоёр зохиомж үүсдэг. Үүнд: **Бүрэн зардлын орлогын тайлан (IS-AC-GM\*)**: Борлуулалтын орлого - Борлуулсан бүтээгдэхүүний өртөг = Нийт ашиг (*GM*). Нийт орлого - Үйл ажиллагааны зардал = Цэвэр орлого. **Шууд зардлын орлогын тайлан (IS-DC-CM\*\*)**: Борлуулалтын орлого - Хувьсах зардал = Ахиуц орлого (*CM*). Ахиуц орлого - Тогтмол зардал = Цэвэр орлого. Эдгээр зохиомжууд пүүсийн инженерчлэлд буй *системийн* маш том хоёр *загвар* билээ. Ерөнхийдөө, шингээгч зардлын орлогын тайланг (*Absorption-Costing Income*) татварын зорилгоор, шууд зардлын орлогын тайланг фирмүүд гол төлөв дотоод менежментэд ашигладаг. Пүүсийн тайлангийн IS-AC-GM загвар - *позитив дүрслэлд*, IS-DC-CM загвар - *норматив дүрслэлд* их нийцтэй юм.

**Тайлбар:** \* - IS-AC-GM: Шингээгч өртгийн сууриар (*AC*) орлого тайлагнахад (*IS*) нийт ашиг (*GM*) үүснэ гэсэн логик санааны англи хэлний товчлол (Жааваа, 2015).

\*\* - IS-DC-CM: Шууд өртгийн сууриар (*DC*) орлого, үр дүнг тайлагнаваас (*IS*) ахиуц ашгийн (*CM*) дүрс үүснэ гэсэн логик утгын англи хэл дээрх товчлол.

**Бүрэн зардлын орлогын тайлагналд (Full-Costing Income)** нийт ашгийн (*Gross*

*Margin*) тэнхлэг үүсч, шууд зардлын орлогын тайлагналд (*Direct-Costing Income*) ахиуц ашгийн (*Contribution Margin*) дүрс үүсдэг нь орчин цагийн пүүсийн онол, эдийн засгийн үнэ цэнийн хэмжлийн загвар, нягтлан бодох бүртгэлийн позитив, норматив дүрслэлд (*Positive & Normative Accounting Theory*) нэгэнт хэвшсэн зүйл юм (Жааваа, 2015). Орчин цагийн пүүсийн онолд алив удирдлагын шийдвэр, шийдлийн үнэ цэнийг өмч, ашиг гэгдэх хоёр дүрс хөтөлдөг болохыг зөвшөөрч, тактикийн шинжтэй богино хугацааны шийдвэрт *ашгийн талбайг*, урт хугацааны шийдвэрт *өмчийн гадаргуйг* тус тус уяж өгсөн нь нууц зүйл биш.

XV зуунаас капитал тохируулгын (*Capital Maintenance*) үзэл дэлгэрч, эздийн өмчийн хэсгээс ашгийн дүрсийг (*Determination of Profit*) заагласан нь пүүсийн онолд эргэлт хийж, орчин цагийн татварын ашгийн тэнхлэг (*APIS*) хийгээд эдийн засгийн ашгийн (*EPMM*) хэмжлийн парадигм дэлгэрэх шимт хөрс болсон. Флоренц худалдаачдын үеэс одоо хэр ашгийн дүрс пүүсийн загварыг хөтлөж буй ч хэтдээ нэмүү өртгийн (*Value Added & Additional Value*) хэмжлүүд илт давамгайлж, систем хөтлөх шинэ эрин үеийн хүлээлт ч үүсч болзошгүй (Жааваа, 2013). Эдүгээ “ногоон” өсөлт (*Green Growth*), орчны нягтлан бодох бүртгэл, нэмүү өртгийн хэмжил ба нийгмийн хариуцлагын (экологи, ажилгүйдэл гэх мэт) тайлагналд их ач холбогдол буй нь үүний харанга дохио байж ч мэднэ. Нэмүү өртөгт суурилсан үндэсний тооцооны систем дотоодын нийт бүтээгдэхүүн, үндэсний орлого, хэрэглээ, хуримтлал зэрэг макро дүрсүүдийг ашгийн дүрсээс илүү дэмжиж хялбаршуулж ч болно.

Санхүүгийн бүртгэлд бүрэн зардлыг дуудах нь нийтийн тогтсон жишиг юм. **APMM** парадигм дагуу, бүрэн зардлаарх пүүсийн **IS-AC-GM** зохиомжоор цэвэр орлогыг инженерчлэхэд, үйлдвэрлэлт ба нийлүүлэлт гэсэн *хоёр хувьсагч* системийг хөтөлж, үр дүнгийн гадаргуйд нөлөөлдөг. Бас бүрэн зардлын үед, уг хувьсагчуудын (нийлээд хослол ашгийг “тэглэж” зохиомол хэмжээс үүсгэдэг) үйлчлэлээс **үлдэгдэл нөөцийн хэлбэлзэл** гэгч гуравдагч *үүсмэл хөтлөгч* гарч ирж, ашгийн дүрсийг зохиомлоор залдаг (жолоодлогогүй болгоно) юм (Жааваа, 2015). Орлого тайлагнах давтамж богиносох тусам, зохиомол хувьсагчийн эрсдэл болон савлагаа улам ихсэнэ.

Харин, пүүсийн **IS-DC-CM** зохиомж, хэмжлийн **EPMM** парадигм, уг нөхцлийг арилгаж, зохиомол хэмжээсээс чөлөөлдөг. Учир нь IS-DC-CM *нээд*, гүн инженерчилсэн гадаргуйд суурилдаг; *хоёрт*, нөөцийн хэлбэлзлээс системийг чөлөөлдөг; *гуравт*, ашиг - нийлүүлэлтээс хамаарсан функцээр дүрслэгдэнэ; *дөрөвт*, тогтмол үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлыг бараа материалын өртөгт суулгаж капиталжуулах үйлдлээс ангижруулна (Жааваа, 2015).

Завсар үеийн төсөвлөлт, сегменчлэл, тайлагналд шууд өртгийн хэрэглээ өсдөг ч урт хугацаанд нөөцийн хэлбэлзэл саармагжих учир бүрэн зардлын тайлагналд шилжих нөхцөл үүсдэг. Нөгөө талаас, ашгийн гүйцэтгэлийг хянах, үйлдвэрлэлт нийлүүлэлтийн хуваарь өөрчлөх, тогтмол үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлын төсвийн нормыг хянах гэхчлэн олон хэмжээст хувьсагчаар дамжуулж, үр дүнгийн талбайг хурдтай залж чиглүүлэхэд бүрэн зардлын хувилбар тустай байдаг.

## Дүгнэлт

1. Нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн систем (A/S) нь санхүүгийн бүртгэлийн мэдээллийн систем (FA/S), удирдлагын бүртгэлийн мэдээллийн систем (MA/S)-ээс бүрдэнэ. Удирдлагын бүртгэлийн мэдээллүүд нь өртгийн бүртгэлийн мэдээллийн систем (CA/S), үйл ажиллагааны хяналтын мэдээллийн систем (OC/S), өртгийн удирдлагын мэдээллийн систем (CM/S) гэсэн дэд системүүдтэй.
2. Системийн суурь категори - эдийн засгийн үнэ цэнэ. Түүний үндсэн шинж тэмдгүүд: а) далд утгатай нууцгай хувьсагч; b) мөнхийн хувьсал хөдөлгөөн хийдэг; с) хязгааргүй хэмжээстэй; d) бүх гадаргүй хэмжигдэхгүй; d) төвөөс зугатах хүч үйлчилдэг.
3. Системийг бүрдүүлэгч гол хоёр дүрс, парадигм (хэмжлийн загвар): а) позитив дүрс - APIS (НББАДӨС, ТЗАДӨС), хэмжлийн парадигм - APMM (НББАХЗ, эсвэл ТЗАХЗ): макро эдийн засгийн үндэсний тооцооны системийг дэмждэг; b) норматив дүрс - EPIS (ЭЗАДӨС), хэмжлийн парадигм - EPMM (ЭЗАХЗ): ой санамж сайн, бизнес хавтгайд буй хараахан мэдрэгдээгүй, далд (бичил) гадаргуйд гүнзгий нэвтэрч, эргэлтэд барьж өгдөг.
4. Системд буй нягтлан бодох бүртгэлийн позитив, норматив дүрсийн онол, үзэл баримтлалын дагуу бизнес хавтгай дэх пүүсийн ашгийн инженерчлэл хийгээд орлого тайлагналд IS-AC-GM (позитив дүрслэлд нийцтэй), тэрчлэн IS-DC-CM (норматив дүрслэлд нийцтэй) системийн суурь зохиомжууд үүсдэг байна.
5. Хэтдээ, хүрэн эдийн засгийг (*People Economics*) таягдаж, ногоон өсөлт, эдийн засагт (*Green Economics*) шилжвээс, өмч, *ашгийн дүрсийн учир холбогдол унаж, нэмүү өртөг, хүртээмжтэй өсөлт (Inclusive Growth)* гэхчлэн хувьсагчуудын орон зай тэлж, системүүдийн холбоос, мэдээллийн технологи болон санхүүгийн тайлангийн хэв загварт үнэмлэхүй хувьсал гарч болзошгүй.

## Ашигласан материал

1. Jaavaa, T. (2007). National Forum on Research Trend and Topic Module, *Economics: Theory and Practice*, 276(17), 5-10.
2. Jaavaa, T. (2007). Measuring Models: Reforming the Modern Mentality", *Journal of Application Standards*, 04(021), 14-15.
3. Jaavaa, T. (2007). Reforming the Modern Mentality and Paradigm of the Measurement Science, *Challenges Facing the Transition Countries in Central Asia*, 290-292.
4. Jaavaa, T. (2008). Boundary of System: Economics and Accounting, *Working Paper - 4th Meeting of Staff in the Field of Finance, Accounting and Economics*, 163-166.
5. Jaavaa, T. (2008). Economics, Theroetical Approach: Engineering and Measurement Model, *International Annual Conference of the Global Academy of Business and Economic Research*, (Orlando, USA, Sep 17-19).

6. Jaavaa, T. (2008), Economic Value: Shaping and Measurement Model, *International Conference of the Business Economics Institute (BEI)*, (Las Vegas, USA, Dec 15-18).
7. Jaavaa, T. (2009). Economic Value: Measuring and Shaping, *International Workshop of Innovation, Bussiness and Economic Development*, (UB, Mongolia, 16 May), 174-183.
8. Jaavaa, T. (2013). The Drivers of Green Growth & Nature of the Financial Report, *Clute Institute International Academic Conference*, (Maui, Hawai, USA, Jan 3-5).
9. Jaavaa, T. (2013). Green Growth: Existence, Heavenism, *Clute Institute International Academic Conference*, (Las Vegas, USA, Sep 22-25).
10. Sainjargal, B., Jaavaa, T., *et al.* (2007). Economics and Professional Structure Reform, *Mongolia in Market Economy*, 352-364.
11. Жааваа, Т. (1994). *Совершенствование системы учета и контроля затрат на производство*, автореф. дис. на соис. кан.экон. наук, 3-23.
12. Жааваа, Т. (2003). *Вопросы обновления системы бухгалтерского учета*, автореф. дис. на соис. док.экон. наук, 3-36.
13. Жааваа, Т. (2016). Стратегия управления себестоимости в Монголии, *Бизнес ба инноваци*, 06(04), 123-130.
14. Жааваа, Т. (2010). Зардал, удирдлагын бүртгэл дэх хувьслын чиг ба сургалтын хандлага, *Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт сэтгүүл*, 1(3), 1-3.
15. Жааваа, Т. (2012). Ногоон эдийн засгийн хөтлөгч ба санхүүгийн тайлагналын дүр зураг, *"Монгол улсын эдийн засаг, бизнесийн судалгаа" МУИС, ЭЗС эрдэм шинжилгээний бичиг №361*, 238.
16. Жааваа, Т. (2015). *Удирдлагын нягтлан бодох бүртгэл, сургалтын үзүүлбэр, бодлого, дасгал, тест*, 6 дэх хэвлэл, 13-16, 35-47, 68-71, 107-109.
17. Жааваа, Т. (2015). Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн мэргэжил, төлөвшил, шинжилгээ: онол, практик, туршилт, үр дүн, нэг сэдэвт товхимол, 250-255, 271-274.